# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 01 өдөр Дугаар 01/436 Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 68 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сүхбаатар дүүргийн 68 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 96,651,333.70 (ерэн зургаан сая зургаан зуун тавин нэгэн мянга гурван зуун гучин гурван төгрөг далан мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 68 дугаар цэцэрлэг (Б.Отгонтуяа)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 93,335,273.70 (ерэн гурван сая гурван зуун гучин таван мянга хоёр зуун далан гурван төгрөг далан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 8 нэр төрлийн 3,316,060.00 (гурван сая гурван зуун арван зургаан мянга жар) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 600,000.00 (зургаан зуун мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 180,000.00 (нэг зуун наян мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн 68 дугаар цэцэрлэг (Б.Отгонтуяа)-т үүрэг болгосугай

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны ..... дүгээр сарын ...-ны өдрийн ..... дугаар тушаалын хавсралт

# Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Сүхбаатар дүүргийн 68 дугээр цэцэрлэг

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон огноо | Дахин үнэлсэн орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл /хавсаргасан баримт/ | ӨХБЗ-ийн дүгнэлт | Байгууллагын үнийн санал | НӨХГ-ын мэргэжилт-ний дүгнэлт | ЭБХХХК-н шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цэцэрлэгийн хашаа | 1973.01.01 | 2019.01.01 | м | 1 | 2,998,895.00 | 2,998,895.00 | 890,296.68 | 2,108,598.32 | эвдэрсэн | актлах | 80,000.00 | 80,000.00 | 80,000.00 |
| 2 | Цэцэрлэгийн дулааны шугам | 1973.07.01 | 2019.01.01 | м | 54.5 | 1,586,696.97 | 86,474,984.86 | 31,678,881.67 | 54,796,103.19 | эвдэрсэн | актлах | 300,000.00 | 300,000.00 | 400,000.00 |
| | **Барилга байгууламжийн дүн** | | | | **55.5** | **4,585,591.97** | **89,473,879.86** | **32,569,178.35** | **56,904,701.51** | | | | | |
| 1 | Программ | 2007.12.05 | | ш | 1 | 770,000.00 | 770,000.00 | 770,000.00 | - | эвдэрсэн | актлах | | устгах | устгах |
| 2 | Өмчийн программ | 2009.01.06 | | ш | 1 | 180,000.00 | 180,000.00 | 180,000.00 | - | эвдэрсэн | актлах | | устгах | устгах |
| | **Программ хангамж** | | | | **2** | **950,000.00** | **950,000.00** | **950,000.00** | - | | | | | |
| 1 | Хүүхдийн ширээ | 2013.03.17 | | ш | 100 | 21,505.00 | 2,150,500.00 | 2,150,500.00 | - | эвдэрсэн | актлах | | 50,000.00 | 50,000.00 |
| 2 | Хүүхдийн сандал | 2013.03.17 | | ш | 100 | 13,640.00 | 1,364,000.00 | 1,364,000.00 | - | эвдэрсэн | актлах | | 50,000.00 | 50,000.00 |
| 3 | Тоглоомын тавиур | 2013.03.17 | | ш | 1 | 112,200.00 | 112,200.00 | 112,200.00 | - | эвдэрсэн | актлах | | устгах | устгах |
| 4 | Сургалтын хэрэгслэл шүүгээ | 2013.03.17 | | ш | 1 | 138,600.00 | 138,600.00 | 138,600.00 | - | эвдэрсэн | актлах | | устгах | устгах |
| 5 | Эмнэлгийн ор | 2013.03.17 | | ш | 1 | 107,800.00 | 107,800.00 | 107,800.00 | - | эвдэрсэн | актлах | | устгах | устгах |
| 6 | Багш ширээ | 2013.03.17 | | ш | 2 | 130,000.00 | 260,000.00 | 260,000.00 | - | эвдэрсэн | актлах | | - | устгах |
| 7 | Хүү сандал | 1998.01.01 | | ш | 94 | 3,690.36 | 346,893.84 | 346,893.84 | - | эвдэрсэн | актлах | | 20,000.00 | 20,000.00 |
| 8 | Самбартай сампин тоглоом | 2013.03.17 | | ш | 1 | 76,340.00 | 76,340.00 | 76,340.00 | - | эвдэрсэн | актлах | | устгах | устгах |
| 9 | Хувцасны шүүгээ | 2015.10.04 | | ш | 8 | 208,890.00 | 1,671,120.00 | 1,671,120.00 | - | эвдэрсэн | актлах | | устгах | устгах |
| | **Тавилга эд хогшил** | | | | **308** | **812,665.36** | **6,227,453.84** | **6,227,453.84** | - | | | | | |
| | **Нийт данснаас хасах хөрөнгийн дүн** | | | | **366** | **6,348,257.33** | **96,651,333.70** | **39,746,632.19** | **56,904,701.51** | | | | | |
| | Үүнээс: Худалдах хөрөнгө | | | | 5 | | 93,335,273.70 | | | | | 380,000.00 | 500,000.00 | 600,000.00 |
| | Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | | | | | | | |
| | Устгах хөрөнгө | | | | 8 | | 3,316,060.00 | | | | | | | |
| | Худалдсанаас олох орлого | | | | | | | | | | | | | |
| | НӨХГ-т төвлөрүүлэх /30%/ | | | | | | | | | | | 114,000.00 | 150,000.00 | 180,000.00 |